



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/102

Арвайхээр

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Зорилтот жил болгон зарлах тухай” 12/04 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Өвөрхангайд үйлдвэрлэв” зорилтот жилийн ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг худалдан авалтаар дэмжин ажиллахыг сумдын Засаг дарга, Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагийн дарга нарт тус тус даалгасугай.


3. Зорилтот жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж ажиллахыг Ажлын хороо (Ц.Ганболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ГАНБОЛД

011100225



Аймгийн Засаг даргын 2020 оны 03
дугаар сарын 18-ны өдрийн захирамжийн хавсралт

“ӨВӨРХАНГАЙД ҮЙЛДВЭРЛЭВ” ЗОРИЛТОТ ЖИЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэгч байгууллага болон ажлын хорооны гишүүд	
			1 дүгээр улиралд	Сумын Засаг дарга нар
1. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд				
1.1	Сум бүр “Өвөрхангайд үйлдвэрлэв” зорилтот жилийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллах		Сумын Засаг дарга нар	
1.2	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа орон нутагт үйлдвэрлэсэн бараа материал, ажиллах хүчийг хамгийн ихээр ашиглах оролцогч нарт давуу эрх тооцож үнэлэх	Жилдээ	Сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар	
1.3	Улс, орон нутгийн төсөв болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын ажилд орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, ажиллах хүчийг түлхүү ашиглуулах ажлыг зохион байгуулах	Жилдээ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, хот барилга, байгуулалтын газар	
1.4	Халамжийн сангаас зорилтот бүлгийн иргэдэд олгох хүнсний эрхийн бичигт орон нутгийн үйлдвэрлэгчдийн мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, гурилан бүтээгдэхүүнийг олгож байх	Жилдээ	Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Сумын Засаг дарга нар	

1.5	Төсөвт байгууллагын албан хэрэгцээнд худалдан авах бараа, бүтээгдэхүүнийг нэн тэргүүнд орон нутгаас худалдан авах талаар албан даалгавар гаргаж “Орон нутгийн үйлдвэрлэл-борлуулалтыг дэмжье” аяныг зохион байгуулах	Жилдээ	Н.Дулам	
1.6	Аймгийн брэнд бүтээгдэхүүний лого бүтээх уралдаан зарлаж, шалгаруулах, логог ашиглах журам батлаж хэрэгжүүлэх	1 дүгээр улирал	Н.Дулам	
1.7	Аймгийн “Зураач, урчуудын шилдэг бүтээл”-ийн болон “Өвөрхангайд үйлдвэрлэл” орон нутгийн шилдэг бүтээгдэхүүний танилцуулга бүхий каталог тус тус гаргаж сурталчлах, цахим мэдээллийн сан үүсгэх	Жилдээ	Н.Дулам, Ц.Ариунаа	
1.8	Үйлдвэр эрхлэгчдийг гадаад болон улс, бүсийн үзэсгэлэн худалдаанд зохион байгуулалттай оролцуулах гадаад, дотоодын туршлага судлах аялалд хамруулах	Жилдээ	Б.Ууганбаяр	
1.9	Үйлдвэр эрхлэгчдийн талаар мэдээллийн сан бий болгох	2 дугаар улирал	Ц.Ариунаа	
1.10	Орон нутагт үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнээ худалдан авч дотоодын үйлдвэрлэлээ дэмжих уриалга гарган олон нийтэд сурталчилах	1 дүгээр улирал	Ц.Ариунаа	
1.11	Орон нутагт үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнүүдийг стандарт хангуулах талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах, тохирлын гэрчилгээ олгох	Жилдээ	Аймгийн Засаг даргын дэргэдэх Стандарт, хэмжил зүйн хэлтэс	
1.12	Аймгийн үйлдвэр эрхлэгчдийн талаар болон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг телевиз болон цахим сүлжээгээр видео контент, нэвтрүүлэг хийж хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчилан таниулах	Жилдээ	Н.Дулам, Н.Гуамарал	
1.13	Цахим худалдаа зохион байгуулж, орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх	Жилдээ	Ц.Ариунаа, Ц.Цэвэлсүрэн	
1.14	Нийтийн хоолны фестивал, ур чадварын уралдаан зохион байгуулах	3 дугаар улирал	Ц.Ариунаа	
1.15	Зорилгот жилийн ажлын хэсгийн төлөөлөл Улаанбаатар хотод “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв”-үүдийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах	1 дүгээр улирал	С.Ундрах	
1.16	Мэргэжилтэй ажилтан бэлтгэж, үйлдвэр эрхлэгчдийг ажиллах хүчээр хангах асуудлыг судлаж, шийдвэрлүүлэх	Жилдээ	С.Ундрах	

1.17	“Өвөрхангайд үйлдвэрлэв” зорилтот жилийн ажлын үр дүнг тооцох, хаалтын арга хэмжээг зохион байгуулж, идэвх санаачилгатай ажилласан сум, байгууллага, бүтээгдэхүүнийхээ чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадвараа сайжруулсан аж ахуйн нэгж, иргэдийг шагнаж урамшуулах, алдаршуулах	4 дүгээр улирал	Н.Дулам, Ц.Ариунаа
2. Үйлдвэр эрхлэгчдийг дэмжих зорилтын хүрээнд			
2.1	Аймгийн өв дамжсан зураач, урчуудын бүтээлийн үзэсгэлэн гаргаж, тэднийг улсын хэмжээнд сурталчлан алдаршуулах ажлыг зохион байгуулах	Жилдээ	Аймгийн Засаг даргын Тамгын газар /цаашид АЗДТГ гэх/
2.2	Өвөрхангай аймгийн онцлог түүхэн өв уламжлалыг харуулсан бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих	Жилдээ	Н.Дулам, Ц.Ариунаа
2.3.	Үндэсний дээл хувцас, гоёл чимэглэлийн чамин тансаг хийц, өнгө, бэлгэдлийн гүн утга агуулгаараа дахин давтагдашгүй өвөрмөц хэв шинжийг бий болгосон уран хатгамлын урлаг, өв соёлын биет хэлбэрийг дэмжин ажиллах	Жилдээ	Н.Дулам, Ц.Ариунаа
2.4	Аймгийн брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх боломжтой бүтээгдэхүүний судалгаа гаргаж, сав, баглаа боодлын дэмжлэг үзүүлэх	Жилдээ	Н.Дулам, Ц.Ариунаа
2.5	Өвөрхангайд үйлдвэрлэв үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	3 дугаар улиралд	Ц.Ариунаа, Б.Ууганбаяр
2.6	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг ажлын байраа нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэх, бүтээгдэхүүнийхээ өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд хөнгөлөлттэй зээлээр дэмжих	Жилдээ	ЖДҮХС, АЗДТГ
2.7	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бичил үйлдвэр эрхлэгчдийг сургах хөгжүүлэх, төсөл хөтөлбөрт хамруулах	Жилдээ	ХЭДС, С.Ундрах
2.8	Өрхийн үйлдвэрлэл болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих	Жилдээ	СХС, Сумын Засаг дарга нар
2.9	Сумдын зорилтот жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллах	Жилдээ	Н.Дулам
2.10	Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах худалдааны төвийг Арвайхээр суманд байгуулах, аж ахуйн нэгж, иргэдэд бизнес мэдээлэл зөвлөгөө өгөх үйлчилгээг хувийн хэвшлийг түшиглэн бий болгох	Жилдээ	Г.Баясгалан, аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа,

		Барилга, байгуулалтын газар	хот
2.11	Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хархорин сум дахь гурил, тэжээлийн үйлдвэрийг орон нутгийн өмчид шилжүүлэн авах талаар судлах, Бат-Өлзий суманд сүү, сүүн бүтээгдэхүүн, Арвайхээр суманд арьс, шир боловсруулах үйлдвэр ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх	Жилдээ	Н.Дулам, Ц.Ариунаа
2.12	Сумдад бөөрөнхий сонгины үрээр хангах, үрсэлгээ бойжуулах хүлэмжийн дэмжлэг үзүүлэх	2 дугаар улирал	Ц.Ариунаа
2.13	Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийн үеэр орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	Жилдээ	Ц.Ариунаа, Т.Ариунболд